

"ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20.....онысарынөдөр

Дугаар №.....06

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын Онцгой нөхцөл бүхий
хөдөлмөрийн гэрээг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, 84 дүгээр зүйлийн 84.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолын 1.1 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх түр журам”-ын 2.7, 2.8, 2.9, Эрчим хүчний сайдын 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн а/76 дугаартай тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирилтай байгуулсан 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг 78 оноогоор “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Бямбажавын Бат-Эрдэнэтэй Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг энэхүү тогтоол өвлийн өдрөөс эхлэн 1 (нэг) жилийн хугацаатай байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3. Компанийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, өртөг зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр авлагыг барагдуулах талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:



ТӨРИЙН ӨМНИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

ДАГАДГИЛ 607/2024 01.02.2024